



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/350

Алтай хот

Боловсролын салбарын Ёс зүйн  
зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/243 дугаар тушаалаар баталсан "Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3, 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэд "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, Насан туршийн боловсролын төвийн багш, удирдах ажилтан болон бусад ажилтны ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчил гаргасан талаарх асуудлыг шалгаж, хариуцлага хүлээлгэх үндэстэй эсэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2."Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, Насан туршийн боловсролын төвийн багш, удирдах ажилтан болон бусад ажилтны ёс зүйн дүрэм"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, ёс зүйн зөрчил, хариуцлагын талаар мэдээллийн сан бүрдүүлж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ф.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 10 дугаар  
06 дугаар сарын 02-ний өдрийн 1359 дугаар  
захирамжийн хавсралт

### ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Г Чинбат -(Аймгийн Засаг даргын орлогч)  
Гишүүд: С.Мөнхжаргал -(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)  
Б Алтайбаатар -(Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн  
газрын дарга)  
Н Байгалмаа -(Боловсрол, шинжлэх ухааны газрын  
математик, физик, мэдээлэл зүйн  
боловсрол хариуцсан мэргэжилтэн)  
О.Хишигжаргал -(Хантайшир эрдэм цогцолбор сургуулийн  
захирал)  
Б Нацагдорж -(Ерөнхий боловсролын лаборатори 1  
дүгээр сургуулийн монгол хэлний багш)  
Ж.Бодьгэрэл -(Сургууль, цэцэрлэгийн эцэг эхийн  
төлөөлөл)  
Нарийн бичгийн дарга: Ж.Амгаланбаатар-(Боловсрол, шинжлэх ухааны газрын  
даргын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгч)

---oOo---